

УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ҮНЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

Ж.Чимгээ^{1,a}, А.Нарандарь^{2,b}

¹Доктор, профессор, Мандах их сургууль

²МУИС, Бизнесийн сургууль

chimgee@mandakh.edu.mn, narandari@gmail.com

Хураангуй

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт 2019 онд 13,7¹ тэрбум ам.долларт хүрчээ. Үүнээс импорт 6.1 тэрбум ам.доллар, экспорт 7.6 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 7% өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.доллараар ашигтай гарсан нь нийт экспортын орлогын 82.9%-ийг эзэлсэн уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан үзүүлэлт юм. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нь Чулуун нүүрс байсан ба 2019 онд 3 тэрбум ам.долларын, 36 сая тонн чулуун нүүрс БНХАУ руу экспортолжээ.

Монгол улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2019 онд 12 040,3 тэрбум төгрөг байснаас уул уурхайн салбарын орлого 3138,5 тэрбум төгрөгт хүрсэн нь нэгдсэн төсвийн орлогын 26,1%-ийг эзэлж байна. Дээрх уул уурхайн гаралтай 6.3 тэрбум ам.долларын эрдэс бүтээгдэхүүнээс Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 1425.7 тэрбум төгрөгийн татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн² байна.


Түлхүүр үг: Уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, борлуулалтын үнэ

¹ ГЕГ. Гадаад худалдааны статистик 2020

² Сангийн Яам. 2019 оны Төсвийн орлогын гүйцэтгэл. 2020

ОРШИЛ

Монгол улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг дахь экспортын бүтээгдэхүүний орлогын нөлөөлөл нэмэгдэж байгаа өнөө үед экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнийн тухай асуудал нь эдийн засаг, худалдааны чухал сэдэв болоод байна. Уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох суурь болдог. Роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь байгалийн баялагаас ард түмэн ашиг хүртэх хэрэгсэл болдог. Иймээс АМНАТ-ийн хувь хэмжээ, төлбөр тооцох суурь зэрэг нь энэхүү сэдвийг судлах үндэслэл болсон юм.



Зураг 1. Монгол улсын засгийн газрын орлого 2011-2019³

Энэ чиглэлээр Дэлхийн банк 2006 онд “Mining Royalties нь хөрөнгө оруулагчид, засгийн газар, иргэний нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаархи дэлхийн хэмжээний судалгаа хийсэн байдаг. Монгол улсын тухайд Судлаач Г.Бямбахүү “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зарим асуудал” 2014 судалгаандаа Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ерөнхий ангилал, бусад орны ашигт малтмалын төрөл зүйлээс шалтгаалсан татварын хувь хэмжээг харьцуулан судалснаар Монгол Улсын АМНАТ-ын эрх зүйн орчинг сайжруулах, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн эдийн засгийн агуулгын ойлголт, түүнийг тооцох суурь тооцоог бодит жишээгээр авч үзсэнээр боловсруулах үйлдвэрээс илүү хүдэр олборлолтод бага АМНАТөлбөр ногдож байгааг харуулсан. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач Б.Түвшинтөгс “Уул уурхайн салбарын татварын урамшуулал” 2019 судалгаандаа уул уурхайн салбарын татварын орчин, түүн дотроо татварын урамшуулал, олон улсын туршлага зэрэг нь Монгол улсад хэрэгжих боломж байгаа юу гэсэн асуултанд хариулт өгсөн байна. Энэхүү судалгааны ажилд статистик судалгааны арга ашиглан Эрдэс бүтээгдэхүүний борлуулалтын үнэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг төмрийн хүдрийн

³ Сангийн яам. Төсвийн орлогын гүйцэтгэл 2020

экспортын 4000 гаруй бүрдүүлэлтийн мэдээн дээр үндэслэн хийлээ. Эндээс уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогчдод тулгардаг томоохон асуудал болох бүтээгдэхүүний үнэ тогтооход тулгардаг асуудлуудыг харуулахыг зорилоо.

1. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1 Экспортын бүтээгдэхүүний гаалийн үнэлгээ


Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн⁴ Зүйл 16.1.Экспортын барааны гаалийн үнэ нь Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлогдоно. гэж заасан байдаг. Монгол банкнаас хийсэн Экспортын орлогын шинжилгээнд⁵ дурдсанаар банкны системээр дамжин орж ирж буй экспортын бодит орлого Гаалийн ерөнхий газраас гаргадаг Экспортын орлогын төвшинд хүрэхгүй байгааг онцолсон байна. Тухайлбал Монголын улсын гадаад худалдааны статистик мэдээллээр Монгол улс 2019 онд Хятад руу 6774.2 сая долларын бараа экспортолсон гэж бүртгэсэн байхад, Хятадын статистикийн мэдээллээр 6329.2 сая ам.долларын бараа Монгол улсаас импортолсон гэж бүртгэжээ. Нийт зөрүү 455 сая ам.доллар буюу 7% байгаа⁶ нь экспортын барааны борлуулалтын үнийн талаар анхаарах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол улсын экспорт, БНХАУ-ын имспортын харьцуулалт, 2010-2019 он

⁴ ГТГТТХууль 2008

⁵ Монгол банк. Экспортын орлогын шинжилгээ. 2013

⁶ ГЕГ. Гадаад худалдааны статистик тохируулга. 2020



Зураг 2. Монгол Улс, БНХАУ Харьцуулсан статистик

1.2 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох хууль эрх зүйн зохицуулалт

Ашигт малтмалын тухай хууль.

47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47.1. Доор дурдсан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна:

47.1.1. ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч;

47.1.2. ашигт малтмал экспортолсон этгээд;

47.1.3. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд.

47.2. Энэ хуулийн 47.16-д заасан борлуулалтын үнэлгээг дараах журмаар тооцно:

47.2.1. экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

47.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараах хэмжээгээр ногдуулна:

47.3.1. олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний **2.5** хувь;

47.3.2. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний **5.0** хувь байх бөгөөд энэ хуулийн 47.5-д заасан хувиар нэмэгдүүлж тооцохгүй;

47.3.3. энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний **5.0** хувь.” гэж заажээ.

Засгийн газрын тогтоол. Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай Засгийн газрын 2016 оны 81 дугаар тогтоолоор Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэр, Монголбанкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг баталж өгсөн байдаг.

Хүснэгт 1. Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр

№	Экспортын бүтээгдэхүүний нэр	Үнийн эх сурвалжийн нэр
1	Алт	Тухайн өдрийн Монголбанкнаас зарласан үнэд үндэслэнэ
2	Мөнгө	Тухайн өдрийн Монголбанкнаас зарласан үнэд үндэслэнэ
3	Төмөр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал гадаадын зах зээлд борлуулахаар байгуулсан гэрээний үнэ
4	Төмөр	Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ нийтэлдэг “www.umetal.com” цахим хуудсанд нийтэлсэн үнэ
		Төмөр, төмрийн хүдэр, баяжмалын үнийн хоёр эх сурвалжийг зааж өгсөн байдаг. Энэ нь Гаалийн байгууллага, Татварын байгууллага хоёр өөр үнэ үндэслэх хуулийн боломж олгодог.
5	Хайлуур жонш	Хятадын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB үнэ (www.indmin.com)
6	Нүүрс	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нүүрсийг гадаадын зах зээлд борлуулахаар байгуулсан гэрээний үнэ
7	Нүүрс	БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн үнэ (“http://en.sxcoal.com)
		Нүүрсний үнийн 2 эх сурвалж зааж өгсөн бөгөөд ямар тохиолдолд, аль эх сурвалжийн үнийг хэн, хэрхэн хэрэглэх талаар тусгаж өгөөгүй.
8	Перренат аммони	Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ нийтэлдэг “www.asianmetal.com” цахим хуудсанд нийтэлсэн үнэ (ренийн давс)
9	Гянтболд	Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ нийтэлдэг “www.asianmetal.com” цахим хуудсанд нийтэлсэн үнэ
10	Мангани	Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ нийтэлдэг “www.asianmetal.com” цахим хуудсанд нийтэлсэн үнэ

Ашигт малтмалын тухай хуулийн 47.6 47.12 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журмыг 2019 оны Засгийн газрын 342 дугаар тогтоолоор шинэчлэн батласан. Засгийн газрын 2019 оны 465-р нэмэлт өөрчлөлт оруулж Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төв байгууллага борлуулалтын үнэлгээг тооцох маягт гарган ашиглах эрх зүйн үндсийг тавьж өгсөн байна.

Монгол улсаас бүтээгдэхүүн импортолдог ОХУ, БНХАУ улсуудын экспортын үйл ажиллагаа болон экспортын үнэлгээний практик туршлагыг авч үзлээ. Мөн уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортоор дэлхийд тэргүүлдэг Австрали, Канад, Чили улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох аргачлалын талаар авч үзлээ.

- **Бүгд Найрамдах Хятад Ард Улс.** БНХАУ-д Газрын тос болон газад 5-10 хувиар, бусад ашигт малтмалуудад 0.3-60⁷ юаниар тооцож барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тооцож төлбөр ногдуулдаг. Харин давсанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахдаа түүний төрөл, хэмжээ, олборлож буй аргаас хамааруулан өөр өөр аргачлалаар төлбөр ногдуулдаг онцлогтой байна.
- **Оросын Холбооны Улс.** ОХУ-д газрын тосноос бусад уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны ногдуулахдаа олон улсын зах зээлийн үнийг баримтлах талаар тухайлан заасан хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд борлуулалтын буюу гэрээний үнээс улсаас олгосон татаас, НӨАТ, тээврийн болон даатгалын зардал зэргийг хассан дүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулж байна. Төлбөрийн үнэлгээний хэмжээ дунджаар 0-8 хувь байдаг бол нүүрс, антрацид, нефтийн бүтээгдэхүүний нэгжид 11-700 рубль буюу барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тооцогддог байна.
- **Австрали.** Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг муж улс бүр өөрийн хуулиар тусгайлан тогтоодог⁸ байна. АМНАТ тооцохдоо дунджаар Хүдэр- 7,5%, Баяжмал-5%, Цэвэр металл-2,5% тухайн бүтээгдэхүүний борлуулалтын орлогод үндэслэж тооцдог⁹ байна.
- **Канад.** Татвар ногдох орлогоос хайгуулын зардлыг хасаж тооцож болдог. Муж бүр төлбөр уул уурхайн компаниудыг шинэ хайгуулын төсөл эхлүүлэх эсвэл хайгуулаа үргэлжлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хайгуулыг идэвхжүүлэх тусгай хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. АМНАТ-ийг цэвэр ашгийн 5% ногдуулдаг¹⁰ байна.

2. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ҮНЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

⁷ OECD. Trade in Services (indicator). 2019

⁸ Г.Бямбахүү “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зарим асуудал” 2014

⁹ Б.Түвшинтөгс “Уул уурхайн салбарын татварын урамшуулал” 2019

¹⁰ Ч.Хашчулуун “Уул уурхайн салбарын гэрээ” 2019

2.1 Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын үнэд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн /нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр/ экспортолдог 300 орчим аж ахуй нэгж, иргэний 2019 онд хийсэн гадаад худалдааны гэрээнээс харахад нийт экспортлогчийн 27 % нь Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, үлдсэн 73% нь дотоодын хөрөнгө оруулалттай байна¹¹. Гэрээлэгч улсын хувьд 90% нь БНХАУ байгаа ба бусад оронтой гэрээ хийсэн ч тэр нь зуучлагч орон болж, хүлээн авагч нь БНХАУ байсаар байна. Иймээс экспортын хувьд нэг орноос хэт хамааралтай байдлыг бууруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дээрх аж ахуй нэгжүүдийн 2019 онд бүрдүүлэлт хийсэн нийт мэдүүлгээс сонгон түүвэрлэж 4052 Төмрийн хүдрийн хэлцлийн үнэд¹² нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг SPSS програм дээр хийж гаалийн олон хувьсагчтай регрессийн шинжилгээ хийлээ. Дээрхи 4052 барааг харилцан хамааралгүй худалдагч, худалдан авагчийн хооронд хийсэн гэж үзээд тухайн хэлцэлд Гаалийн байгууллага, Бараа нийлүүлэх нөхцөл (БНН) болон Тээврийн төрлийн үзүүлэх нөлөөллийг судаллаа. Гадаад худалдааны хэлцлийн үнийг ердийн байдлаар харьцуулахад үнийн ялгаа ажиглагдахгүй байсан бол Регрессийн шинжилгээгээр Үнэд нөлөөлөх нөлөө их байгааг харж болно.

Хэлцлийн дундаж үнэд нөлөөлөх хүчин зүйлс

Хүснэгт 2. Хүчин зүйлийн шинжилгээ. Үр дүн

	Дундаж /USD/	Хэлцлийн тоо	Стандарт хазайлт
Нийт	41.474	4052	5.807
Хөрөнгө оруулалтын төрөл			
Үндэсний хөрөнгө оруулалттай ААН	41.633	1805	2.697
Гадаадын хөрөнгө оруулалттай ААН	41.289	1653	7.252
Бусад	41.508	594	7.847
Бараа нийлүүлэх нөхцөл			
DAF	38.694	232	6.289
DAP	41.667	2359	5.554
EXW	45.000	877	0.000
FCA	36.507	584	6.877

¹¹ Гаалийн мэдүүлэгт хавсаргасан Гадаад худалдааны гэрээнд хийсэн дүн шинжилгээ

¹² Санамсаргүй сонголтын аргаар гаалийн газар хороодоос сонгон авав

Тээврийн төрөл			
Авто зам	43.215	1075	5.274
Төмөр зам	40.846	2977	5.864
Гаалийн бүрдүүлэлт хийсэн байгууллага			
Замын-Үүд ГГ	41.459	111	6.795
Дорнод ГГ	27.460	87	0.846
Дархан-Уул ГГ	40.846	2977	5.864
Говь-Алтай ГГ	45.000	877	0.000

- Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн гэрээний дундаж үнэ 41,289 \$ байсан бол Үндэсний хөрөнгө оруулагчид харьцангуй өндөр буюу дунджаар 41.633 \$ байсан байна.
- Бараа нийлүүлэх нөхцөл ихэвчлэн DAP нөхцөлөөр хийгдсэн байх ба энэ нөхцөлөөр хийгдсэн гэрээний дундаж үнэ 41.667 \$ байна. Худалдагчийн хувьд хамгийн бага байх ёстой EXW нөхцөлөөр хийгдсэн хэлцлийн дундаж үнэ 45 \$ байгаа нь хамгийн өндөр байгаа нь Экспортлогчид экспортын нөхцөлөө төдийлөн зөв, ашигтай сонгож чаддаггүй гэдгийг харуулж байна. Дотоодын татвар хураамжийн зардал төлөгдсөн FCA нөхцөлд худалдагчийн хувьд бага үнээр бараагаа худалдан борлуулах гэрээ хийсэн байна. Эндээс дүгнэхэд гадаад худалдаа эрхлэгчид гэрээндээ олон улсын худалдааны нөхцөлийг оновчтой тусгаж, өөрсдийн худалдааны үйл ажиллагааг хамгаалж чаддаггүй нь харагдаж байна.
- Төмрийн хүдрийг төмөр замаар тээвэрлэх үед дундаж үнэ 40.846\$ байгаа бол авто замаар тээвэрлэвэл 43.215 \$ болж 1,4\$ өндрөөр зарах боломжтой болдог байна. Төмөр замаар нэвтрэх хурд удаан, төмөр замын тээврийн олдоц хүрэлцээгүй, зардал өндөр байдгаас шалтгаалан борлуулалтын дундаж үнэ өндөр байдаг зэрэг шалтгаанаас хамааран гэрээний үнэ бага байх магадлалтай. Иймээс төмөр замын хүртээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах боломжийг судлах хэрэгтэй гэж үзэж байна.
- Гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллагыг тухайн гаалийн газар хороо байршдаг нутаг дэвсгэрээр төлөөлүүлэн оруулаа. Тухайлбал, Замын-Үүд дэх гаалийн газраар бүрдүүлэлт хийсэн бүтээгдэхүүнийг Дорноговь аймгаас олборлосон, бусад гаалийн газраар бүрдүүлэлт хийсэн бараа нь тухайн аймгаас олборлосон бүтээгдэхүүн гэж үзсэн болно. Нийт бүрдүүлэлтийн 74 хувь нь Дархан уул аймаг дахь Дархан гаалийн газраар бүрдүүлэлт хийсэн байх бөгөөд дундаж үнэ нь 40.846\$ байна. Замын-Үүд дэх гаалийн газраар бүрдүүлэлт хийсэн бүтээгдэхүүний дундаж үнэ нь 41.459 \$ байна. Говь-Алтай аймаг дахь Гаалийн газраар бүрдүүлэлт хийсэн бүтээгдэхүүний дундаж үнэ 45.0\$ байгаа нь тухайн бүтээгдэхүүний агууламж, худалдааны зардал бага байх магадлалтайг харуулж байна. Харин Дорнод аймаг дахь гаалийн газраар хийсэн бүтээгдэхүүний дундаж

үнэ 42.460\$ байгаа нь дунджаас хэт бага үнэ буюу тухайн бүтээгдэхүүний чанар, агууламж бага, худалдааны зардал өндөр гардагтай холбоотой байна.

Иймд экспортын хэлцлийн дундаж үнийн харьцуулалтыг хийснээр цаашид экспортын орлогыг нэмэгдүүлэхийн тулд аль гаалийн газраар, ямар тээврийн хэрэгслээр, худалдааны ямар нөхцөлд гэрээ хийх вэ гэдгийг тодорхойлоход түлхэц болох боломжтой юм.

2.2 Регрессийн шинжилгээний үр дүн

Дээрх мэдээлэлд регрессийн шинжилгээ хийж үр дүнг тайлбарлалаа.

Хүснэгт 2. Регрессийн шинжилгээний үр дүн

	Загвар	
	(a)	(b)
(Constant)	-999.312 (113.852)	-20.991 (2.673)**
cs=Orange	2.773 (0.166)**	0.060 (0.004)**
cs=RED	3.827 (0.228)**	0.084 (0.005)**
Ам.доларын ханш	0.388 (0.042)**	0.009 (0.001)**
'3' DAF 'Авто зам'	-15.315 (0.962)**	-0.342 (0.023)**
'6' DAF 'Авто зам'	-25.222 (0.956)**	-0.651 (0.022)**
'13' DAF 'Төмөр зам'	-13.514 (0.907)**	-0.315 (0.021)**
'13' DAP 'Төмөр зам'	-8.878 (0.842)**	-0.191 (0.020)**
'13' FCA 'Төмөр зам'	-16.128 (0.852)**	-0.381 (0.020)**
'17' EXW 'Авто зам'	-5.738 (0.852)**	-0.114 (0.020)**

a. Хамааран хувьсагч: Price /USD/

b. Хамааран хувьсагч: Логарифм Price /USD/

**99 хувийн итгэх түвшинд, статистик ач холбогдолтой

Загвар (а) -ийн үр дүнгээс 1 тонн төмрийн хүдрийн үнэ,

- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран CS үр дүн **'Orange'** бол **'Green'**¹³-тэй харьцуулахад дунджаар 2.773 ам.доллараар дээгүүр;
- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран CS үр дүн **'Red'** бол **'Green'**-тэй харьцуулахад дунджаар 3.827 ам.доллараар дээгүүр;
- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ба CS үр дүн зэргээс үл хамааран **ам.долларын ханш 10** төгрөгөөр нэмэгдэх нь 1 тонн **төмрийн хүдрийн** үнийг дунджаар 3.88 доллараар нэмэгдүүлж байна;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'3', DAF, 'Авто зам'** нөхцөлтэй бол суурь¹⁴ бүлгээс 15.315 ам.доллараар доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'6', DAF, 'Авто зам'** нөхцөлтэй бол суурь бүлгээс 25.222 ам.доллараар доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'13', DAF, 'Төмөр зам'** нөхцөлтэй бол суурь бүлгээс 13.514 ам.доллараар доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'13', DAP, 'Төмөр зам'** нөхцөлтэй бол суурь бүлгээс 8.878 ам.доллараар доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'13', FCA, 'Төмөр зам'** нөхцөлтэй бол суурь бүлгээс 16.128 ам.доллараар доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'17', EXW, 'Авто зам'** нөхцөлтэй бол суурь бүлгээс 5.738 ам.доллараар доогуур байна.

Загвар (b) -ийн үр дүнгээс 1 тонн төмрийн хүдрийн үнэ,

- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран CS үр дүн **'Orange'** бол **'Green'**¹⁵-тэй харьцуулахад дунджаар 6% дээгүүр;
- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран CS үр дүн **'Red'** бол **'Green'**-тэй харьцуулахад дунджаар 8.4% дээгүүр;
- Гаалийн байгууллага, БНН ба тээврийн төрөл ба CS үр дүн зэргээс үл хамааран **ам.долларын ханш 10** төгрөгөөр нэмэгдэх нь 1 тонн **төмрийн хүдрийн** үнийг дунджаар 9% нэмэгдүүлж байна;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран **'3', DAF, 'Авто зам'** нөхцөлтэй бол суурь¹⁶ бүлгээс 34.2% доогуур;

¹³ CS үр дүнгийн суурь бүлэг

¹⁴'3' DAP 'Авто зам (суурь бүлэг)

¹⁵ CS үр дүнгийн суурь бүлэг

¹⁶ '3' DAP 'Авто зам (суурь бүлэг)

- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран '6', DAF, 'Авто зам' нөхцөлтэй бол суурь бүлгээс 65.1% доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран '13', DAF, 'Төмөр зам' нөхцөлтэй бол суурь бүлгээс 31.5% доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран '13', DAP, 'Төмөр зам' нөхцөлтэй бол суурь бүлгээс 19.1% доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран '13', FCA, 'Төмөр зам' нөхцөлтэй бол суурь бүлгээс 38.1% доогуур;
- CS үр дүн ижил үед, ам.долларын ханшаас үл хамааран '17', EXW, 'Авто зам' нөхцөлтэй бол суурь бүлгээс 11.4% доогуур байна.

Эндээс экспортын бүтээгдэхүүний уурхайн орд, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллага, тээврийн зардал Хэлцлийн үнэд ихээр нөлөөлдөг болохыг харж болно.

ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн засаг, төсөв уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний экспортын орлогоос ихээхэн хамааралтай байдаг. Нийт экспортын 82.9%-ийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын орлогоос бүрдүүлж байгааг статистик мэдээллээс харж болно. Экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээр үнэлэх гол хэрэгцээ шаардлага нь эрдэс бүтээгдэхүүнээс Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авч, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх явдал юм. АМНАТ-өөс 2019 онд улсын төсөвт 1425.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн экспортлогчид бүтээгдэхүүний үнэ тогтоохдоо бүтээгдэхүүний агууламж, чанар, стандарт зэргийг харгалзан худалдан авагчтай хэлэлцсэн гэрээний үнийг тогтоодог. Ийнхүү үнэ тогтооход тээврийн төрөл, олборлолт явуулж буй орон нутаг буюу бүрдүүлэлт хийх гаалийн газар хороо, бараа нийлүүлэх нөхцөл, гэрээний валютын ханш зэрэг үзүүлэлт голлох нөлөө үзүүлдэг байна. Үүнээс валютын ханш экспортын бүтээгдэхүүний үнэд хамгийн гол нөлөө үзүүлдэг хүчин зүйл аж.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг их хэмжээгээр экспортлох бус тухайн бүтээгдэхүүнээ хамгийн бага зардлаар, өндөр үнэ хүргэж борлуулах нь худалдааны ашгийг хамгийн өндөр байлгах боломжтойг дээрх судалгаа харууллаа. Мөн гадаад худалдааны гэрээндээ Инкотермс буюу олон улсын худалдааны нөхцөлийг зөв ашиглаж чадвал зардал, эрсдэлээ худалдан авагчид хариуцуулах, экспортлогч талд гарах аливаа эрсдэлийг бууруулах боломжтой. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг өндөр байлгаснаар улсын төсөвт төвлөрүүлэх Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдэх бүрэн боломжтой. АМНАТ тооцох суурь болсон борлуулалтын үнэлгээг дэлхийн зах зээлийн үнээр үнэлэх, гадаад худалдааны гэрээний үнээр үнэлэх ялгааг бүтээгдэхүүн бүр дээр тодорхой ялгаж өгөх хэрэгцээ байгаа тул

тухайн салбарын хууль эрх зүйн зохицуулалтыг нэг мөр болгох шаардлага тулгараад байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. James Otto, Craig Andrews, Fred Cawood, Michael Doggett Pietro Guj Frank Stermole John Stermole John Tilton (2006) Mining Royalties A Global Study of Their Impact on Investors, Government, and Civil Society. The International Bank for Reconstruction and Development / The World Bank
2. Сэсээр.Г (2000) Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал. Улаанбаатар хот. Монгол
3. Минжин.Л (2009) Гааль, татварын холбогдолтой хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн эмхэтгэл. Улаанбаатар хот. Монгол
4. Батнасан.Н (2003) Гадаад худалдаа:Үйлажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар хот. Монгол
5. Баярсайхан.Д (2019) Монгол улсын гаалийн холбогдолтой олон улсын гэрээний тойм. Улаанбаатар хот. Монгол
6. Нарантуяа.Н (2017) Судалгааны арга зүй. Улаанбаатар хот. Монгол
7. Түвшингэрэл.Т. (2015) Экспортын орлогын шинжилгээ. Монгол банк. Улаанбаатар хот. Монгол
8. Түвшинтөгс.Б (2019) Уул уурхайн салбарын татварын урамшуулал. ЭЗСЭШХ. Улаанбаатар хот. Монгол
9. Хашчулуун.Ч (2019) Уул уурхайн салбарын гэрээ. ЭЗСЭШХ. Улаанбаатар хот. Монгол
10. Бямбахүү.Г. (2014) ХААИС. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зарим асуудал. Улаанбаатар хот. Монгол
11. Гаалийн тариф, гаалийн татаварын тухай хууль 2008
12. Ашигт малтмалын тухай хууль 2014
13. Татварын ерөнхий хууль 2019

14. Засгийн газрын тогтоол 2014 дугаар 81, 82 “Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай”
15. Засгийн газрын тогтоол 2019 дугаар 342 “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам”
16. Засгийн газрын тогтоол 2019 дугаар 465 “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”
17. ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан эрх зүйн актын эмхэтгэл УБ. 2020
18. Татварын ерөнхий газрын даргын тушаал. Тайлангийн маягт батлах тухай 2019 ТТ15
19. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаал 2020. Маягт батлах тухай